



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/95

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, "Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчийн үйлдвэрийн газартай 2022 оны хамтын ажиллагааны гэрээ"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2022 оны хамтын ажиллагааны гэрээ"-ний хөрөнгө оруулалтаас Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж 20,000,000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тус хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

